



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 22 өдөр


Дугаар 1/31

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, Зэвсэгт хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам”-ыг нэгдүгээр, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга хурандаа Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хошууч генерал Д.Ганзориг нарт даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын “Журам батлах тухай” 2011 оны 230 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т хариуцуулсугай.



1321100043

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
22 дугаар сарын 22-ны өдрийн 11 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ
БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид “журам” гэх/-ын эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчиний тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай Монгол Улсын хуулиуд болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж байна.

1.3. Журмын үйлчлэлд Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллага /цаашид “төрийн цэргийн байгууллага” гэх/, Тагнуул, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага /цаашид “хууль сахиулах байгууллага” гэх/-ын алба хаагч хамаарна.

1.4. Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), бүс нутгийн холбогдох бусад байгууллага, ажиллагаа явагдаж байгаа болон хамтран оролцох улс орны зүгээс энэ журамд зааснаас өөр тусгайлсан нөхцөл, шалгуурыг тавьсан тохиолдолд НҮБ-ын дүрэм, олон улсын гэрээний заалттай нийцүүлэн дагаж мөрднө.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 3.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах нэр томьёог дор дурдсанаар ойлгоно:

2.1.1. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэргийн алба хаагч” гэж энхийг дэмжих ажиллагааны удирдах албан тушаалтан, штабын ажилтан, цэргийн мэргэжилтнээр томилогдсон офицер, ахлагчийг.

Гурав. Сонгон шалгаруулалтын хэлбэр, тавигдах шаардлага,
шалгалтын төрөл, зохион байгуулалт

3.1. Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалт нь дараах хэлбэртэй байна:

3.1.1. цэргийн алба хаагчийн;

3.1.1.1. удирдах албан тушаалтны;

3.1.1.2. штабын ажилтны;

3.1.1.3. цэргийн мэргэжилтний.

3.1.2.цэргийн багийн удирдлагын;

3.1.3.цэргийн багийн бие бүрэлдэхүүний.

3.2. Энхийг дэмжих ажиллагааны албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл, гүйцэтгэх үүргийн онцлогийг харгалзан энэхүү журмын 3.1.1, 3.1.2-т заасан цэргийн алба хаагч гэдэгт дараах албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг хамруулж ойлгоно:

3.2.1.энэ журмын 3.1.1.1-т заасан удирдах албан тушаалтанд цэргийн хүчний командлагч, командлагчийн орлогч, НҮБ-ын төв штабын Энхийг сахиулах ажиллагааны газарт удирдах, түүнтэй дүйцэх албан тушаалд болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны алба, нэгжийн дарга, нэгдсэн штабын удирдах албан тушаалын орон тоонд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг;

3.2.2.энэ журмын 3.1.1.2-т заасан штабын ажилтанд цэргийн хүчний командлалын штабын дарга, хэлтсийн дарга, бүсийн командлагч, командлагчийн орлогч, штабын дарга, штабын офицер, ахлагчийн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг;

3.2.3.энэ журмын 3.1.1.3-т заасан цэргийн мэргэжилтэнд цэргийн ажиглагч, цэргийн холбогч офицер, цэргийн ахлах зөвлөх, цэргийн зөвлөхийн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг;

3.2.4.энэ журмын 3.1.2-т заасан цэргийн багийн удирдлагад энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон Зэвсэгт хүчний батальон /рот, тусгай нэгж/-ы захирагч, захирагчийн орлогч, штабын дарга, батальон /рот, тусгай нэгж/-ы ахлагч нарыг.

3.3. Энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнд дараах нийтлэг шаардлага тавигдана:

3.3.1.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1-т заасан нийтлэг үүрэг, Цэргийн албаны тухай хуулийн 19.2-т заасан шалгуур үзүүлэлт болон төрийн албан хаагчийн ёс зүйн шаардлагыг хангасан байх;

3.3.2.цэргийн зохих шатны мэдлэгтэй, мэргэжлийн болон багаар ажиллах ур чадвартай байх;

3.3.3.албан тушаалын үүргийн биелэлт, цэргийн сахилга, сургалт бэлтгэлийн дүнгээр В-ээс доошгүй үнэлэгдсэн байх;

3.3.4.цэргийн эмнэлгийн комиссын үзлэгээр орж, биеийн эрүүл мэндээр тэнцсэн байх;

3.3.5.хамт олны дунд нэр хүндтэй, зан харьцаа, ёс суртахууны хувьд төлөвшсөн, гэмт хэрэг, сахилгын зөрчил гаргаагүй байх;

3.3.6.болзошгүй цагийн байдал, эрсдэлийг үнэлэх, түүнийг даван туулах бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилттэй байх;

3.3.7.цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдаж, цэргийн тангараг өргөсөн, цэргийн цолтой байх.

3.4. Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай байна.

3.5. Энэ журмын 3.1.1.2, 3.1.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь НҮБ-ын холбогдох сургалт, дамжааг дүүргэж, сертификат авсан байна.

3.6. Энэ журмын 3.1.1-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчид дараах тусгай шаардлага тавигдана:

3.6.1.энэ журмын 3.2.1-т заасан албан тушаалд үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 20-оос дээш жил цэргийн алба хаасан, дэд хурандаа, түүнээс дээш цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 80-аас дээш оноо авсан, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах, нэгдсэн штабт ажиллах, англи хэлээр баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.2.энэ журмын 3.2.2-т заасан цэргийн хүчний командлалын штабын дарга, бүсийн командлагчаар үүрэг гүйцэтгэхээр штабын ажилтны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 20-оос дээш жил цэргийн алба хаасан, хурандаа, бригадын генерал цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 80-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд энэ журмын 3.6.3-т заасан аль нэг албан тушаалд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах, англи хэлээр баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.3.энэ журмын 3.2.2-т заасан цэргийн хүчний командлалын хэлтсийн дарга, бүсийн командлагчийн орлогч, штабын дарга, штабын ахлах офицeroор үүрэг гүйцэтгэхээр штабын ажилтны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 16-аас дээш жил цэргийн алба хаасан, дэд хурандаа, хурандаа цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 80-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд цэргийн мэргэжилтэн, штабын офицeroор үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, нэгдсэн штабт ажиллах, англи хэлээр штабын төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.4.энэ журмын 3.2.2-т заасан штабын офицeroор үүрэг гүйцэтгэхээр штабын ажилтны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 12-оос доошгүй жил цэргийн алба хаасан, ахмад, хошууч, дэд хурандаа цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 75-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд цэргийн мэргэжилтнээр үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, англи хэлээр штабын төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.5.энэ журмын 3.2.2-т заасан штабын ахлагчаар үүрэг гүйцэтгэхээр штабын ажилтны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 8-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахлах ахлагч, түүнээс дээш цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 75-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд 2-оос доошгүй удаа үүрэг гүйцэтгэсэн, албан хэрэг хөтлөх, англи хэлээр баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.6.энэ журмын 3.2.3-т заасан цэргийн ажиглагч, цэргийн холбогч офицероор үүрэг гүйцэтгэхээр цэргийн мэргэжилтний сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 10-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахмад, хошууч, дэд хурандаа цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоо шалгалтад 70-аас дээш оноо авсан, англи хэлээр хэлэлцээр хийх, баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай, радио холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, байршил тогтоогчийг ашиглах чадвартай, 5-аас доошгүй жил тээврийн хэрэгсэл жолоодсон, механик хурдны хайрцагтай автомашин /4x4/-ыг жолоодох ур чадвартай, техник хэрэгсэлд өдөр тутмын техникийн үйлчилгээг бие даан хийх дадлага, туршлагатай байх;

3.6.7.энэ журмын 3.2.3-т заасан цэргийн ахлах зөвлөх, цэргийн зөвлөхөөр үүрэг гүйцэтгэхээр цэргийн мэргэжилтний сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 15-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахлах офицерын цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоо шалгалтад 80-аас дээш оноо авсан, нэгдсэн штабт ажиллах, англи хэлээр төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай, радио холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, байршил тогтоогчийг ашиглах чадвартай, 5-аас доошгүй жил тээврийн хэрэгсэл жолоодсон, механик хурдны хайрцагтай автомашин /4x4/-ыг жолоодох ур чадвартай, техник хэрэгсэлд өдөр тутмын техникийн үйлчилгээг бие даан хийх дадлага, туршлагатай байх.

3.7. Энэ журмын 3.1.1-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь энэ журмын 3.3-т заасан нийтлэг шаардлага, энэ журмын 3.6-д заасан тусгай шаардлагаас гадна НҮБ, бус нутгийн бусад холбогдох байгууллага, ажиллагаа явагдаж байгаа болон хамтран оролцох улс орны зүгээс тавьсан шаардлагуудыг хангасан байна.

3.8. Энэ журмын 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчид дараах тусгай шаардлага тавигдана:

3.8.1.энэ журмын 3.2.5-д заасан батальоны захирагчаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 20-оос дээш жил цэргийн алба хаасан, дэд хурандаа, хурандаа цэргийн цолтой, стратеги, тактик, команд-штабын мэргэжилтэй, англи хэлний ахисан дунд түвшний мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.2.энэ журмын 3.2.5-т заасан ротын захирагчаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 15-аас доошгүй жил цэргийн алба хаасан, хошууч, дэд хурандаа цэргийн цолтой, команд тактикийн офицер мэргэжилтэй, гадаад хэлний ахисан дунд түвшний мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.3.энэ журмын 3.2.5-т заасан тусгай нэгжийн захирагч /дарга/-аар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 15-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахлах офицерын цэргийн цолтой, тухайн чиглэлийн мэргэжлийн сургууль төгссөн, командын офицер мэргэжилтэй, гадаад хэлний ахисан дунд түвшний мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.4.энэ журмын 3.2.5-т заасан батальон /рот, тусгай нэгж/-ы захирагчийн орлогч, штабын даргаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох

цэргийн алба хаагч нь 15-аас дээш жил цэргийн алба хаасан, хошууч, дэд хурандаа цэргийн цолтой, команд тактикийн офицер мэргэжилтэй, гадаад хэлний дунд түвшний мэдлэгтэй, штабын ажлын туршлагатай, цэргийн албыг удирдан зохион байгуулах чадвартай байх;

3.8.5.энэ журмын 3.2.5-т заасан батальон /рот, тусгай нэгж/-ы ахлагчаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 10-аас дээш жил цэргийн алба хаасан, ахлах ахлагч, түүнээс дээш цэргийн цолтой, ахлагчийн ахисан түвшний сургалт, дамжааг төгссөн, гадаад хэлний дунд түвшний мэдлэгтэй, даргалах ахлагчийн албан тушаалд ажилласан туршлагатай, цэргийн албыг зохион байгуулах чадвартай байх.

3.9. Энэ журмын 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох алба хаагчийн насны дээд хязгаарыг Цэргийн албаны тухай хуулийн 10.5, 11.4, 11.5-д заасны дагуу тогтооно.

3.10. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн багийн гүйцэтгэх үүргийн онцлогийг харгалзан цэргийн багийн бие бүрэлдэхүүнд тавигдах нэмэлт шаардлагыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага /цаашид “ЗХЖШ” гэх/ тогтооно.

3.11. Энэ журмын 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг нэг нэгтгэл, ангийн тасаг, салаа, ротоор бүрдүүлэх бодлогыг баримтална.

3.12. Хууль сахиулах байгууллагын алба хаагчийг энэ журмын 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцуулж болно.

3.13. Албан ажлын хэрэгцээ шаардлага, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ журмын 3.7-д заасан тусгай шаардлагыг хангаагүй боловч энэ журмын 3.3-т заасан нийтлэг шаардлагыг хангасан, зэвсэгт хүчинд 15-аас дээш жил цэргийн алба хаасан офицер, ахлагчийг өөрийн хүсэлт, нэгтгэл, анги, байгууллагын тодорхойлолтыг үндэслэн энэ журмын 3.1.1.2, 3.1.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцуулж болно.

3.14. Сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас дараах төрлийн шалгалтыг авна.

3.14.1.Биеийн тамирын бэлтгэл;

3.14.2.Гадаад хэлний бэлтгэл;

3.14.3.Замын хөдөлгөөний дүрэм, жолоодлогын дадлага;

3.14.4.Мэргэжлийн ур чадвар;

3.14.5.Хууль эрх зүйн бэлтгэл.

3.15. Энэ журмын 3.14.1-т заасан шалгалтыг ЗХЖШ-ын даргын 2017 оны А/505 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын дагуу зохион байгуулж, шалгаж үнэлэх ба алба хаагч нь бие бялдрын бэлтгэлжилтийг 70-аас дээш хувиар биелүүлсэн байна.

3.16. Энэ журмын 3.14.2-т заасан шалгалтыг англи хэлний түвшин тогтоох шалгалт /ALCPT/ болон шаардлагатай тохиолдолд герман, франц хэлний түвшин тогтоох шалгалтын дагуу зохион байгуулж, унших, ярих, сонсох болон бичих чадварыг шалгаж үнэлнэ.

3.17. Энэ журмын 3.14.3-т заасан шалгалтыг Монгол Улсын замын хөдөлгөөний тухай хууль тогтоомжийн хүрээнд дүрмийн мэдлэгийг тестийн аргаар, тэнцсэн тохиолдолд механик хурдны хайрцагтай автомашин /4x4/-ыг жолоодох ур чадварыг автодром дээр болон замын хөдөлгөөнд оролцуулж шалгаж үнэлнэ.

3.18. Энэ журмын 3.14.4-т заасан шалгалтыг радио болон сансрын холбооны хэрэгсэл, байрлал тогтоогчийг ажилд бэлтгэх, ажиллуулах, компьютерын өргөн хэрэглээний программыг ашиглан ажиллагааны баримт бичиг боловсруулах ур чадварыг дадлагаар, болзошгүй цагийн байдлыг үнэлж, шийдвэр гаргах ур чадварыг дасгал боловсруулах аргаар явуулж, шалгаж үнэлнэ.

3.19. Энэ журмын 3.14.5-д заасан шалгалтыг олон улсын хууль эрх зүй, Зэвсэгт мөргөлдөөний хууль, конвенц, НҮБ-ын дүрэм, Монгол Улсын Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж, энхийг дэмжих ажиллагааны эрх зүйн баримт бичгийн мэдлэгийн түвшинг тестийн аргаар зохион байгуулж, шалгаж үнэлнэ.

3.20. Энэ журмын 3.1.1.1-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас НҮБ болон бус нутгийн холбогдох байгууллагаас тавьсан шалгуур үзүүлэлтийг удирдлага болгон энэ журмын 3.14.2, 3.14.5-д заасан шалгалтыг авна.

3.21. Энэ журмын 3.1.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас энэ журмын 3.14.1, 3.14.2, 3.14.4-т заасан, энэ журмын 3.1.1.3-т заасан цэргийн алба хаагчаас энэ журмын 3.14.1, 3.14.2, 3.14.3, 3.14.4-д заасан шалгалтыг тус тус авна.

3.22. Энэ журмын 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас энэ журмын 3.14.1, 3.14.2, 3.14.4-т заасан, энэ журмын 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас энэ журмын 3.14.1, 3.14.2-т заасан шалгалтыг тус тус авна. Шаардлагатай гэж үзвэл тусгай мэргэжилтэй алба хаагчаас ур чадварын нэмэлт шалгалтыг авч болно.

3.23. Энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна:

3.23.1.алба хаагч нь энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/-д бичгээр гаргана;

3.23.2.нэгтгэл, анги, байгууллага нь сургуулийн жилийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөлттэй уялдуулан энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх боломжтой бүрэлдэхүүний мэдээллийг жагсаалтаар гаргаж, харьяалах байгууллагын мэргэжлийн газар, хэлтэс, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаар дамжуулан ЗХЖШ-т тухайн оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ;

3.23.3. ЗХЖШ нь Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайдын тушаалыг үндэслэн мэргэжлийн газар, хэлтэс, төрийн цэргийн болон хууль сахиулах

байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан тухайн жилд энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бүрэлдэхүүний тоог 15 хүртэлх хувийн нөөцийн бүрэлдэхүүнтэй байхаар ажиллагаа тус бүрээр тогтоож, төлөвлөгөө, графикийн дагуу холбогдох байгууллагуудаар дамжуулан нэгтгэл, анги, байгууллагад хүргүүлнэ;

3.23.4.нэгтгэл, анги, байгууллага нь энэ журмын 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан бүрэлдэхүүнээс энэ журмын 3.14.1-т заасан шалгалтыг авч тэнцсэн алба хаагчдын хүсэлт, сурлагын дүн, ажлын үзүүлэлт, эрүүл мэнд, сахилга харийцлагын байдлыг захирагч /дарга/-ийн зөвлөлийн хурлаар хүн нэг бүрээр хэлэлцэн шийдвэр гаргаж, энэ журмын 3.23.5-д заасан материалыг 2 дугаар хавсралтад заасан судалгааны хамт бүрдүүлж, харьяалах байгууллагын мэргэжлийн хэлтэс, газар, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаа дамжуулан ЗХЖШ-т хүргүүлнэ.

3.23.5.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх сонгон шалгаруулалтад оролцох алба хаагч нь дараах материалыг бүрдүүлнэ:

3.23.5.1.сайн дурын үндсэн дээр энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлт бүхий гараар бичсэн өргөдөл;

3.23.5.2.ажил байдлын тодорхойлолт;

3.23.5.3.нэгтгэл, анги, байгууллагын дарга /захирагч/-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл;

3.23.5.4.офицер, ахлагч /цэргийн гэрээт алба хаагч/-ийн үнэмлэхийн хуулбар (цол, албан тушаалд томилогдсон хуудасны хамт);

3.23.5.5.сүүлийн 3 сард авхуулсан 4x6 см-ийн хэмжээтэй цээж зураг 3 хувь;

3.23.5.6.цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

3.23.5.7.гадаад паспортын хуулбар /хүчинтэй хугацаа 3-аас дээш жил/;

3.23.5.8.энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргасан ар гэрийн баталгаа.

3.23.6.энэ журмын 3.1.1.3 болон 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад орох алба хаагч нь гүйцэтгэх албан тушаалын үүргийн онцлогоос шалтгаалан жолооны үнэмлэх, мэргэжлийн дамжаа төгссөн сертификатын хуулбарыг нэмэлтээр бүрдүүлнэ.

3.24. Энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалтыг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон комисс зохион байгуулна.

3.25. Энэ журмын 3.1.1.1, 3.1.2 болон 3.2.2-т заасан цэргийн хүчиний командлалын штабын дарга, бүсийн командлагчаар үүрэг гүйцэтгүүлэх штабын ажилтны сонгон шалгаруулалтын комисст БХЯ-ны төлөөллийг оролцуулна.

3.26. Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох бүрэлдэхүүнийг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд энэ журмын 3.24-т заасан комисс танилцуулна.

3.27. Энэ журмын 3.2.1-т заасан НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны алба, нэгжийн дарга, нэгдсэн штабын удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагч нь ЗХЖШ-ын дарга болон БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрөлгүйгээр бие даан сонгон шалгаруулалтад орохыг хориглоно.

3.28. Энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалтад орох алба хаагчийн биеийн эрүүл мэндийн байдлыг Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-д заасны дагуу цэргийн эмнэлгийн комисс тодорхойлж, дүгнэлт гаргана.

3.29. ЗХЖШ энэ журмын 3.1.1.2, 3.1.1.3-т заасан сонгон шалгаруулалтыг “Соёмбо” сонин болон БХЯ, ЗХЖШ-ын вэбсайт [/https://www.mod.gov.mn/](https://www.mod.gov.mn/); <https://www.gsmaf.gov.mn/gsmaf/>-аар нээлттэй зарлана.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Цэргийн зохих шатны сургууль, дамжаа төгссөн, цэргийн гэрээт албанд элссэн болон шинэ албан тушаалд томилогдоноос хойш 12 сараас доошгүй хугацаагаар алба хаасан офицер, ахлагч, түрүүч, байлдагч энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ гаргаж болно.

4.2. Цэргийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд өмнө нь 6 сарын хугацаагаар үүрэг гүйцэтгэсэн бол 12 сарын дараа, 12 сарын хугацаагаар үүрэг гүйцэтгэсэн бол 24 сарын дараа энэ журмын 3.1-т заасан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ гаргаж болно.

4.3. Алба хаагчийг дараах тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй:

4.3.1.баримт бичиг дутуу бүрдүүлсэн;

4.3.2.эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаагүй;

4.3.3.сонгон шалгаруулалтын явцад сахилгын зөрчил гаргасан болон гэмт хэрэг, зөрчилд холбогдож эрх бүхий байгууллагад шалгагдаж байгаа;

4.3.4.энэ журмын 4.2-т заасан хугацааг баримтлаагүй бол;

4.3.5.батлан хамгаалахын болон бусад их, дээд сургууль, коллежийн өдрийн ангийн сургалт, дамжаанд сурч байгаа;

4.3.6.Төрийн албаны тухай хууль, цэргийн сахилгын дүрэмд заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй;

4.3.7.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонгон шалгаруулалтын нэгдсэн ажиллагаанд 3-аас дээш удаа хоцорсон.

4.4. Сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой аливаа маргаантай асуудлыг комисс тухай бүр хянан шийдвэрлэнэ. Сонгон шалгаруулах комиссын шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл сонгон шалгаруулалтад оролцогч нь ЗХЖШ-ын дарга, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад өргөдөл, гомдол гаргаж болно.

4.5. Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оOо---

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН АР ГЭРИЙН БАТАЛГАА

..... Улсад
явагдаж байгаа Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр сайн дурын үндсэн
дээр хүсэлт гарган, сонгон шалгаруулалтад тэнцсэн Зэвсэгт хүчний
..... дугаар ангийн
..... албан тушаалтай
..... цолтой овогтой –ийн ар гэрийг
бүрэн төлөөлөх эрхтэй /эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, эгч, дүү/ (доогуур зурах)
..... би энэ ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэхийг
зөвшөөрч байна.

АР ГЭРИЙГ ТӨЛӨӨЛЖ:

..... / / огноо
/эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, эгч, дүү. /
доогуур зурах, нэрээ бүтнээр бичиж, гарын үсэг зурна)

/Иргэний үнэмлэхийн хуулбар/

АНГИ, БАЙГУУЛЛАГААС ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭГДСЭН СУДАЛГАА ИРҮҮЛЭХ МАЯГТ


/огноо/

№	Цэргийн цол	Овог ,нэр	Албан тушаал	Анги, байгууллагад ажилласан жил	Регистрийн дугаар	Гадаад паспортын дугаар	Гадаад паспортын дуусах хугацаа	Боловсрол	Ажиллагааны туршлага	Гадаад хэлний мэдлэг

..... дугаар анги /байгууллага/-ийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга /хүний нөөцийн удирдлага/-ын цол овог нэр

.....

---oOo---



Батлан хамгаалахын сайдын 2021 оны
22 дугаар сарын 22-ны өдрийн 13 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ,
ЦЭРГИЙН БАГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СУРГАЖ БЭЛТГЭХ, ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭХ ҮЕД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулж явуулах, үүрэг гүйцэтгэх болон үүрэг гүйцэтгэсний дараах зохион байгуулалтын арга хэмжээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмын эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль, Монгол Улсын соёрхон баталсан болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид “НҮБ” гэх/-ын дүрэм болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд байна.

1.3. Журмын үйлчлэлд Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллага /цаашид “төрийн цэргийн байгууллага” гэх/, Тагнуул, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага /цаашид “хууль сахиулах байгууллага” гэх/-ын алба хаагч хамаарна.

1.4. НҮБ болон бус нутгийн холбогдох бусад байгууллага, ажиллагаа явагдаж байгаа эсхүл хамтран оролцох улс орны зүгээс энэ журамд зааснаас өөр шаардлага тавьсан тохиолдолд энэ журмын 1.2-т заасныг баримтлан хамтран ажиллах санамж бичиг, техникийн гэрээний хүрээнд сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх харилцааг харилцан зөвшилцэж шийдвэрлэнэ.

Хоёр. Энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэлийг төлөвлөх

2.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн алба хаагч, цэргийн багийн сургалт бэлтгэлийг төлөвлөхдөө Энхийг дэмжих ажиллагаа, олон улсын хамтарсан сургалт дадлагад оролцуулах талаар гарсан Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайдын тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штаб /цаашид “ЗХЖШ” гэх/ - аас батлан гаргасан цэргийн сургалт бэлтгэлтэй холбоотой журам, заавар, стандарт, сургалтын төлөвлөгөөг баримтална.

2.2. Энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчнээс анх удаа цэргийн багийг оролцуулах асуудлыг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 8 дугаар зүйлийн 8.1.1-т заасныг үндэслэн шийдвэрлэнэ.

2.3. Энхийг дэмжих ажиллагаа, түүнтэй холбоотой олон улсын хамтарсан сургалт дадлагын төлөвлөлтийг ЗХЖШ-ын Энхийг дэмжих ажиллагаа хариуцсан

нэгж боловсруулж, бусад холбогдох нэгжүүд бүх талын мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ.

2.4. ЗХЖШ дараа оны энхийг дэмжих ажиллагаа, олон улсын хамтарсан сургалт дадлагад Зэвсэгт хүчнээс зохион байгуулах, оролцох арга хэмжээ, санхүүжилтийг батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төлөвлөлттэй уялдуулан урьдчилсан төлөвлөлтийг жил бүрийн 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор, үндсэн төлөвлөлтийг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор албан бичгээр Батлан хамгаалах яам /цаашид “БХЯ” гэх/-нд хүргүүлнэ.

2.5. Энхийг дэмжих ажиллагаа, олон улсын хамтарсан сургалт дадлагын төлөвлөлтийн талаар БХЯ-ны холбогдох газар, хэлтсийн саналыг яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар нэгтгэж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Батлан хамгаалахын сайдын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

2.6. Энэ журмын 2.5-д заасан шийдвэр гарсны дараа Батлан хамгаалахын сайдын тушаалын төслийг БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтэстэй хамтран боловсруулж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор батлуулна.

2.7. Цэргийн багийн төрөл, гүйцэтгэх үүргээс нь хамаарч зохион байгуулагдах ажиллагааны өмнөх болон ажиллагааны үед явагдах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, шалгаж үнэлэх зааврыг ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтэс, төрлийн цэргийн командлал боловсруулж, ЗХЖШ-ын дарга батална.

2.8. Энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэлийг ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл, ажиллагааны үеийн сургалт бэлтгэл гэсэн үе шатаар төлөвлөж, цэргийн баг, цэргийн алба хаагчийг бэлтгэнэ.

2.9. Энхийг дэмжих ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл болон ажиллагааны дараах зохион байгуулалтын арга хэмжээг ЗХЖШ, ажиллагааны үеийн сургалт бэлтгэлийг цэргийн багийн захирагч энэ журмын 2.7-д заасны дагуу төлөвлөнө.

2.10. Цэргийн багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх хууль сахиулах байгууллагын алба хаагч, тусгай мэргэжилтэй зарим энгийн алба хаагч нь ЗХЖШ-аас гаргасан тусгай төлөвлөгөөний дагуу цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдаж, цэргийн тангараг өргөсөн байна.

2.11. Цэргийн багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх хууль сахиулах байгууллагын алба хаагч, тусгай мэргэжилтэй зарим энгийн алба хаагч нь энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаандаа цэргийн цол, цэргийн дүрэмт хувцас хэрэглэнэ.

Гурав. Энхийг дэмжих ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл

3.1. Энхийг дэмжих ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл /цаашид “сургалт” гэх/ нь энхийг дэмжих ажиллагаанд оролцох алба хаагч нэг бүрийг гүйцэтгэх үүрэгт нь сурган дадлагажуулах, удирдлага, штабын бэлтгэлжилт, салбарын жигдрэлтийг хангаж ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэх бэлтгэлийг хангахад чиглэнэ.

3.2. Сургалт бэлтгэлийн зарчим:

3.2.1.хууль, эрх зүйн үндэслэлтэй байх: Сургалтыг зохион байгуулахдаа Зэвсэгт хүчинд мөрдөж буй хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хүрээнд явуулна;

3.2.2.шинжлэх ухааны үндэстэй байх: Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг судалгаа, тооцоонд үндэслэн боловсруулж, орчин үеийн техник, технологийг өргөнөөр ашиглана;

3.2.3.бодитой байх: Сургалтыг бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн түвшин, ажиллагааны газар орны цагийн байдал, үүрэг гүйцэтгэх орчин нөхцөлтэй уялдуулан гүйцэтгэх үүрэгт нь ойртуулсан байдлаар явуулна.

3.2.4.үян хатан байх: Сургалтыг бие бүрэлдэхүүний ажил мэргэжлийн онцлог, албаны ур чадвар, гүйцэтгэх үүргийн түвшинг харгалзан ялгавартайгаар, төрөл бүрийн арга, хэлбэрийг ашиглан явуулна.

3.3. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга цэргийн багийн бие бүрэлдэхүүнтэй ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай шийдвэр гаргах бөгөөд хувийг БХЯ-нд хүргүүлнэ.

3.4. Сургалтыг Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв, бусад нэгтгэл, анги, байгууллагын сургалтын материаллаг баазыг түшиглэн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв болон цэргийн багийн удирдлага хамтран зохион байгуулна.

3.5. Сургалтын хугацаа нь тухайн ажиллагааны төрөл, мандат, цэргийн багийн гүйцэтгэх үүргийн онцлогоос шалтгаалан 4-8 долоо хоног байна.

3.6. Цэргийн багийн удирдлага, штабын бэлтгэлжилтийг хангах зорилгоор цэргийн багийн удирдлага, штабтай явуулах сургалтыг энэ журмын 2.7-д заасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

3.7. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 3.2-т заасан албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг ЗХЖШ-ын тусгай төлөвлөгөөний дагуу өөрийн улс болон гадаад улсад зохион байгуулагдах олон улсын сургууль, төлөвлөлтийн хурал, семинар болон бусад сургалт дадлагад оролцуулах замаар сургаж бэлтгэнэ.

3.8. Сургалтад хамрагдсан хүн нэг бүрийн бэлтгэл, үүрэг гүйцэтгэх чадварыг энэ журмын 2.7-д заасан шалгаж үнэлэх зааврын дагуу шалгаж үнэлнэ.

3.9. Сургалтын төгсгөлд мотобуудлагын батальоны удирдлага, штабын бэлтгэлжилт, рот /тусгай нэгж/-ын удирдлагын бэлтгэлжилт, мотобуудлагын батальон, рот /тусгай нэгж/-ын жигдрэлтийг энэ журмын 2.7-д заасан шалгаж үнэлэх зааврын дагуу шалгаж үнэлнэ.

3.10. Ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтаас биеийн эрүүл мэнд, сахилга хариуцлага, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн алба хаагчийн талаар ЗХЖШ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт мэдэгдэнэ.

3.11. Энэ журмын 3.10-т заасан шалтгаанаар сургалтаас чөлөөлөгдсөн цэргийн багийн алба хаагчийг нөөцийн бүрэлдэхүүнээс нөхөн бүрдүүлэх боломжгүй тохиолдолд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 3.24-т заасан комисс дээрх журамд заасны дагуу сонгон шалгаруулалт явуулж, ЗХЖШ-ын даргын шийдвэрээр сургалтад хамруулна.

3.12. ЗХЖШ-ын эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгж цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүний дархлаажуулалтын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, баяжилт хийх, шаардлагатай дархлаажуулалтын судалгааг гарган бие бүрэлдэхүүнийг товлолт дархлаажуулалтад хамруулна.

3.13. Энэ журмын 3.7-д заасан ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлд хамрагдсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 3.1.1-т заасан алба хаагчийг томилуулах асуудлыг ЗХЖШ-ын энхийг дэмжих ажиллагаа, хүний нөөц хариуцсан нэгжүүд хамтран ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, саналаа тухай бүр БХЯ-нд хүргүүлнэ.

3.14. Ажиллагааны өмнөх сургалтын дүн болон цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүнийг томилуулах асуудлыг ЗХЖШ-ын энхийг дэмжих ажиллагаа, хүний нөөц хариуцсан нэгж хамтран ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, цэргийн багийг ажиллагааны газар орон руу илгээхээс 7 хоногийн өмнө саналаа БХЯ-нд хүргүүлнэ.

3.15. ЗХЖШ-ын энхийг дэмжих ажиллагаа, сургалтын бодлого хариуцсан нэгжүүд ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтын туршлага, сургамж, үр дүнг тооцож ажиллана.

3.16. Зэвсэгт хүчний хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт шалгалт хариуцсан нэгж энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэлийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргана.

Дөрөв. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх

4.1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын, эсхүл бус нутгийн холбогдох олон улсын байгууллагын явуулж байгаа олон үндэстний энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс оролцох цэргийн баг, алба хаагчдын удирдлагыг олон улсын конвенц, гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дараах байдлаар хэрэгжүүлнэ:

4.1.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн – Төрийн захиргааны удирдлагыг;

4.1.2.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга энхийг дэмжих ажиллагаанд оролцож буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн баг, алба хаагчийн - Цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг;

4.1.3.НҮБ, Олон Улсын байгууллагаас томилсон бүрэн эрхт Тусгай төлөөлөгч, Цэргийн хүчний командлагч /Бүсийн командлагч/-Ажиллагааны /тактикийн/ удирдлагыг;

4.1.4. Зэвсэгт хүчний Жанжин штабын энхийг дэмжих ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжийн дарга- Зэвсэгт хүчний цэргийн баг, алба хаагчдын Цэргийн захиргааны удирдлагыг;

4.1.5. Үндэсний ахлах төлөөлөгч /Үндэсний ахлаач/ - тухайн ажиллагааны Зэвсэгт хүчний цэргийн баг, алба хаагчдын - Үндэсний удирдлагыг.

4.1.6. Цэргийн багийн захирагч - Зэвсэгт хүчний цэргийн багийн захиргааны болон тактикийн удирдлагыг.

4.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг томилно.

4.3. Цэргийн баг үүрэг гүйцэтгэж буй энхийг дэмжих ажиллагаанд Үндэсний ахлах төлөөлөгчийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар, бусад ажиллагаанд Үндэсний ахлаачийг ЗХЖШ-ын даргын шийдвэрээр томилон ажиллуулах ба тэдгээрийн ажиллах журмыг ЗХЖШ-ын дарга тогтооно.

4.4. ЗХЖШ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчтай энэ журмын хавсралтын дагуу гэрээ байгуулах бөгөөд үүрэг гүйцэтгэсэн талаар цэргийн багийн захирагч, Үндэсний ахлах төлөөлөгч болон Үндэсний ахлаачийн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн тухайн цэргийн алба хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэл хийнэ.

4.5. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн урьд эрхэлж байсан албан тушаалыг хэвээр хадгалж, цалин хөлсийг бүрэн олгоно. Албан тушаалын цалин хөлсийг түүнтэй байгуулсан гэрээг үндэслэн итгэмжлэгдсэн этгээдэд олгож болно.

4.6. Олон улсын цэргийн ажиллагаанд цэргийн багт үүрэг гүйцэтгэх алба хаагчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгалд хамруулна. Даатгалд хамруулахтай холбогдон гарах зардлыг Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн төлөвлөлтөд жил бүр тусгана.

4.7. Цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр ниссэн өдрөөс үүрэг гүйцэтгэж эхэлсэнд тооцно.

4.8. Цэргийн алба хаагч, цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүн нь энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үедээ Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөж, Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүд, эрх зүйн хэм хэмжээ, НҮБ-ын дүрэм, олон улсын гэрээ, тухайн ажиллагааны удирдлагаас тогтоосон дүрэм, журмыг чанд сахиж, ажиллагаа явагдаж байгаа улсын хууль тогтоомж, ёс заншлыг хүндэтгэнэ.

4.9. ЗХЖШ нь ажиллагаанд оролцож байгаа бие бүрэлдэхүүн, тэдний үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны үеийн цагийн байдлын талаар өдөр тутмын мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийн, үр дүнг БХЯ-ны удирдлагад танилцуулна.

4.10. Ажиллагааны үеийн сургалт бэлтгэлийг Зэвсэгт хүчний Жанжин штабаас батлан гаргасан цэргийн сургалт бэлтгэлийн журам, заавар, стандарт бусад холбогдох баримт бичгийг баримтлан цэргийн багийн захирагч тусгай төлөвлөгөөр зохион байгуулна.

4.11. Ажиллагааны талаарх зөвшөөрөгдсөн мэдээг олон нийтэд хүргэх, алба хаагчийг ар гэртэйгээ холбогдох нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн баг, алба хаагчийг цэргийн мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангах үүргийг ЗХЖШ хариуцна.

4.12. Ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө ажиллагааны газар орноос эгүүлэн татна.

4.12.1. үүрэг гүйцэтгэх хугацаа дуусгавар болсон;

4.12.2. Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын гэрээгээр тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн;

4.12.3. ЗХЖШ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжтэй байгуулсан гэрээний үүргийг зөрчсөн;

4.12.4. эрүүл мэндийн шалтгаанаар үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй тухай холбогдох байгууллага, албан тушаалтны дүгнэлт гарсан.

4.13. Энэ журмын 4.12.2, 4.12.3-т заасан шалтгаанаар хугацаанаас нь өмнө ажиллагааны газар орноос эгүүлэн татахтай холбогдон гарах зардлыг тухайн алба хаагч хариуцна.

4.14. Ажиллагаанаас эгүүлэн татсан алба хаагчийн оронд үүрэг гүйцэтгэх Зэвсэгт хүчний офицер, ахлагчийг дараах хугацааг харгалзан ЗХЖШ-ын даргын санал болгосноор Батлан хамгаалахын сайд томилж, ажиллагааны газар орон руу илгээхтэй холбогдон гарах зардлыг Батлан хамгаалах яам хариуцна.

4.14.1. 6 сарын хугацаатай ажиллагаанд 4 сар үүрэг гүйцэтгэхээр бол;

4.14.2. 12 сарын хугацаатай ажиллагаанд 6 сар үүрэг гүйцэтгэхээр бол.

4.15. Зэвсэгт хүчний офицер, ахлагч нараас бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагч энэ журмын 4.12.2, 4.12.3-т заасан шалтгаанаар хугацаанаасаа өмнө ажиллагааны газар орноос эгүүлэн татагдсан тохиолдолд түүний оронд үүрэг гүйцэтгэх офицер, ахлагчийг энэ журмын 4.14-т заасан хугацааг харгалзан ЗХЖШ-ын даргын санал болгосноор Батлан хамгаалахын сайд томилж, ажиллагааны газар орон руу илгээх зардлыг тухайн алба хаагчийн харьяаллын төрийн захиргааны байгууллага хариуцна.

4.16. Ажиллагаанд удирдах албан тушаал, штабын ажилтан, цэргийн мэргэжилтнээр үүрэг гүйцэтгэж буй алба хаагч ээлжийн амралт, чөлөөгөөр явах хугацаандаа зорчих хөдөлгөөн, аялалын мэдээллийн талаар ЗХЖШ-ын энхийг дэмжих ажиллагааны асуудал хариуцсан нэгжид мэдэгдэнэ.

4.17. Ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн 30 хүртэл хоногоор үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах асуудлыг тухайн ажиллагааны удирдлага, 30 болон

түүнээс дээш хоногоор сунгах асуудлыг НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газраас ирүүлсэн албан бичиг, ЗХЖШ-ын даргын саналыг үндэслэн Батлан хамгаалахын сайд шийдвэрлэнэ.

4.18. Цэргийн багийн үүрэг гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийг цэргийн багийн удирдлага, штаб хариуцан архивлаж, дараагийн цэргийн багт цахимаар, ЗХЖШ-т хэвлэмэл байдлаар хүлээлгэн өгнө.

4.19. Цэргийн багийн ээлж хүлээлцэх, эгүүлэн татах ажиллагааг Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилогдсон комисс тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах бөгөөд комисс тайлангаа сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

4.20. Цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх хугацааг Монгол Улсын хилээр нэвтэрсэн өдрөөр дуусгавар болсонд тооцно.

Тав. Энхийг дэмжих ажиллагааны дараах зохион байгуулалтын арга хэмжээ

5.1. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгээд эх орондоо ирсэн алба хаагчийг үндсэн албан тушаалд нь томилон ажиллуулах хүртэлх ажиллагааны дараах зохион байгуулалтын арга хэмжээг ЗХЖШ хэрэгжүүлнэ.

5.2. Ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчийг нөхөн сэргээх сувилалд хамруулах бөгөөд хамруулах хуваарь, хамрагдаж буй байдал, үр дүнг ЗХЖШ хариуцна.

5.3. Нөхөн сэргээх сувилалд хамруулах нэг цэргийн алба хаагчид ноогдох хувьсах зардлыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар тогтоон, холбогдох зардлыг Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.

5.4. Шаардлагатай тохиолдолд нийтийг хамарсан халдварт өвчинеэс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлалтын арга хэмжээнд бие бүрэлдэхүүнийг хамруулна.

5.5. Цэргийн багийн захирагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн тухай тайланг нийт бие бүрэлдэхүүн эх орондоо ирснээс хойш 14 хоногийн дотор ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанд, 30 хоногийн дотор Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулна. Шаардлагатай тохиолдолд цэргийн багийн удирдлагын холбогдох албан тушаалтыг байлцуулж болно.

5.6. Цэргийн баг, алба хаагчийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн тухай тайлан нь дараах бүтэцтэй байна:

5.6.1.цэргийн багийн бүтэц, зохион байгуулалт, үүрэг;

5.6.2.ажиллагааны цагийн байдлын өрнөлт, үүсч болзошгүй цагийн байдал, эрсдэлийн үнэлгээ;

5.6.3.ажиллагааны үүрэг гүйцэтгэлт;

5.6.4.байлдааны хангальт;

5.6.5.бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, сэтгэл зүй;

5.6.6.материал, техникийн хангальт;

- 5.6.7.санхүүгийн тайлан;
- 5.6.8.туршлага, сургамж;
- 5.6.9.санал, цаашид анхаарах асуудал;
- 5.6.10.дүгнэлт зэрэг орно.

5.7. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 3.2-т заасан албан тушаалд үүрэг гүйцэтгэсэн алба хаагч энэ журмын 5.6-д заасны дагуу тайлангаа ЗХЖШ-ын энхийг дэмжих ажиллагааны асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжид танилцуулна. Шаардлагатай тохиолдолд 7 хоногийн дотор ЗХЖШ-ын даргын зөвлөлд, 14 хоногийн дотор Батлан хамгаалахын сайдын зөвлөлд танилцуулна.

5.8. Үүрэг гүйцэтгэх хугацаанд онцгой амжилт гаргаж, гавьяа байгуулсан цэргийн алба хаагчийг цэргийн багийн захирагч, цэргийн хүчний командалгачийн тодорхойлолтыг үндэслэн шагнаж урамшуулна.

5.9. Зэвсэгт хүчний цэргийн баг, бие бүрэлдэхүүн энхийг дэмжих ажиллагаанд оролцсон тухай мэдээллийг олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг улсын хэмжээнд БХЯ-ны Төрийн захирагааны удирдлагын газар, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, “Соёмбо” редакц, Монгол цэргийн музей, аймаг, орон нутагт Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, тухайн аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб хариуцна.

5.10. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн баг, алба хаагчийн тайланг ЗХЖШ-ын энхийг дэмжих ажиллагаа хариуцсан нэгж нэгтгэн боловсруулж, туршлага, сургамж, үр дүнг тооцож ажиллана.

5.11. Ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчийн овог, нэр, регистрийн дугаар бүхий мэдээллийн сантай байх бөгөөд БХЯ, ЗХЖШ-ын хүний нөөц, энхийг дэмжих ажиллагаа хариуцсан нэгж мэдээллийн аюулгүй байдлыг хариуцаж, хөтөлнө.

5.12. Ажиллагааны төсөв санхүүтэй холбоотой асуудлыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.12.1.цэргийн багийн захирагч, удирдлага нь цэргийн багийн эд хөрөнгө, НҮБ-ын эд хөрөнгийн талаарх хариуцлагыг Монгол Улсын хууль тогтоомж, НҮБ-ын холбогдох дүрэм, журмын дагуу хүлээнэ;

5.12.2.ажиллагаанд цэргийн багт ашиглагдаж байгаа зэвсэг, техник, материал хэрэгсэл, өмч хөрөнгийг данснаас хасахдаа “Батлан хамгаалахын эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг баримтлан зохион байгуулна;

5.12.3.цэргийн багийн захирагч нь Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан зардал, хуваарилагдсан хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байх бөгөөд зардлын нэр, ангилал хооронд шилжүүлэн зарцуулах шаардлагатай тохиолдолд ЗХЖШ-аар уламжлуулан, зөвхөн Батлан хамгаалахын сайдын тушаалаар өөрчлөлт оруулан зарцуулж болно;

5.12.4.цэргийн алба хаагчаар болон цэргийн багийн захирагчаар үүрэг гүйцэтгэхээр томилогдсон эрх бүхий албан тушаалтанд бэлэн мөнгө, бусад хангалтыг олгоходоо Батлан хамгаалахын сайдын тушаал, холбогдох баримт бичиг, хүсэлтийг үндэслэн БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс ажлын 15-аас доошгүй хоногийн хугацаанд шийдвэрлэнэ;

5.12.5.ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдах болон хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэнэ. Ингэхдээ НҮБ-ын холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэх бөгөөд тухайн алба хаагчийн буруутай үйлдлээс болж /амь насаа санаатайгаар бүрэлгэсэн/ амь нас эрсэдсэн нь тогтоогдвол тэтгэмж олгохгүй;

5.12.6.цэргийн багийн захирагч бие бүрэлдэхүүнд НҮБ-аас сар бүр олгодог болон амралтын мөнгийг тухай бүр алба хаагчид гарг нь олгож, олгосон тухай гарын үсгээр баталгаажуулна;

5.12.7.Батлан хамгаалахын сайдын тушаалаар энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед зарцуулсан бэлэн мөнгө, бусад санхүүгийн холбогдолтой тайлан, баримтыг цэргийн багийн захирагч нийт бие бүрэлдэхүүн эх орондоо ирсэн өдрөөс хойш ажлын 10 хоногт, цэргийн алба хаагч ажлын 7 хоногт багтаан БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан нэгжид хүлээлгэн өгч тайлагнана;

5.12.8.тушаалаар баталсан бэлэн мөнгө, бусад хангалтын материал хэрэгслийг зориулалтын дагуу зарцуулаагүй, санхүүгийн анхан шатны баримт, тайланг үндэслэлгүй буруу гаргаж тайлагнасан болон тайлан баримт ирүүлээгүй албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, эргэн төлүүлэх арга хэмжээ авна;

5.12.9.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэсэн хоногийн тооцоог ЗХЖШ-ын энхийг дэмжих болон санхүү хариуцсан нэгж энэ журмын 4.7, 4.20-д заасныг баримтлан хүн нэг бүрээр тооцож, ажлын 3 хоногт багтаан ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсээр хянуулж, БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлнэ;

5.12.10.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн багийн бие бүрэлдэхүүний нөхөн төлбөрийг Засгийн газраас тогтоосон хэмжээ, энэ журмын 5.12.9-т тооцсон хугацааг үндэслэж Батлан хамгаалахын сайдын тушаалаар олгоно. Гадаад валютын ханшийг цэргийн багийн сүүлчийн ээлж эх орондоо ирсэн өдрийн Монгол банкны ханшаар тооцно;

5.12.11.энэ журмын 4.12.2-4.12.4-т заасан шалтгаанаар үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө ажиллагааны газар орноос ирсэн алба хаагчид үүрэг гүйцэтгэсэн хугацааны нөхөн төлбөрийг энэ журмын 5.12.9-т заасныг баримтлан олгоно;

5.12.12.энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багийн бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техник, эд хөрөнгийг оролцуулсны нөхөн төлбөрийн орлогыг бүрэн бүрдүүлэхтэй холбогдсон арга хэмжээг ажиллагааны газар орон дээр цэргийн багийн захирагч хариуцна. Хэрэв цэргийн багийн захирагчийн буруутай үйл ажиллагаанаас болж нөхөн төлбөрийн орлого буурсан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

5.12.13.энэ журмын 4.19-т заасан комиссын томилолт, визний хураамж, тээврийн зардлыг “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-гаас санхүүжүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүн ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэх хугацаандаа хувьдаа ашиг олох зорилгоор аливаа хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Хууль бус үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Шаардлагатай тохиолдолд цэргийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэлт, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, эд хөрөнгийн ашиглалт, чанар байдалд хяналт хийх, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, шалган туслах зорилгоор БХЯ, ЗХЖШ-ын хамтарсан ажлын хэсгийг ажиллагааны газар оронд болон нийт бие бүрэлдэхүүнийг эх орондоо ирсний дараа томилон ажиллуулж болно.

6.3. Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байхдаа гэмт хэрэг үйлдсэн, захиргааны болон сахилгын зөрчил гаргасан, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн алба хаагчид эх орондоо ирсний дараа холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЦЭРГИЙН
АЛБА ХААГЧТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

Нэг талаас: Зэвсэгт хүчний Жанжин штабын Хүний нөөцийн хэлтсийн дарга
...../цол, овог,
нэр/

Нэгдээ талаас: анги /байгууллага/-д
...../албан тушаал, цол, овог, нэр/

нар Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн сайн дурын үндсэн дээр
Улсад энхийг дэмжих ажиллагаанд оролцох талаар харилцан зөвшөөрч энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний үндсэн нөхцөл

1.1. Энэхүү гэрээнд оролцогч талууд 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл хугацаанд энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, гүйцэтгүүлэх, мөн хугацаанд албан тушаалын цалин хөлс, бусад хангамж, үүрэг гүйцэтгэсэн хугацааны томилолтын зардлыг саадгүй олгох тухай харилцан тохиролцов.

1.2. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагч /цаашид “алба хаагч” гэх/ нь Монгол Улсын хууль тогтоомж; тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм журамд заасан цэргийн албаны онцлогтой холбогдох эрх зүйн байдлын зарим хязгаарлалт, нэмэгдэл үүрэг болон хариуцлага, хөнгөлөлт, давуу байдлыг хуулийн хүрээнд хүлээх буюу эдлэх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн байгууллага, тухайн ажиллагаа явагдаж байгаа улс оронд байгуулсан гэрээнд заасан нийтлэг болон тусгайлан заасан шаардлагыг сахин биелүүлэх үүрэг хүлээнэ.

1.3. Алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаанд төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, цэргийн багийн нийт бие бүрэлдэхүүн болон хувийн аюулгүй байдлыг хангах нэмэгдэл үүргийг хүлээнэ.

Хоёр. Гэрээнд оролцогч талуудын эрх, үүрэг

2.1. Зэвсэгт хүчний Жанжин штабын эрх:

2.1.1. алба хаагчийг энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.1.2. ажиллагаанд оролцох хугацаандаа Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомжийг зөрчин гэмт хэрэгт холбогдсон, захиргааны хариуцлагын, цэргийн сахилгын дүрмийн болон энэ гэрээнд заасан ноцтой зөрчил гаргасан, гэрээний 1.3-д заасан үүргээ зөрчсөн алба хаагчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэгүйд тооцон, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээг цуцлах,

захиргааны санаачилгаар ажлаас халах хүртэлх арга хэмжээг авах бөгөөд үүнтэй холбогдон гарсан зардлыг төлүүлэх;

2.1.3.архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Цэргийн сахилгын дүрэм, цэргийн алба хаагчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нараас гаргасан тушаал, албан даалгаврыг зөрчсөн нь энэ гэрээний 2.1.2-д заасан ноцтой зөрчилд тооцогдоогүй бол Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг бууруулах, мөн хуулийн 48.1.3-т зааснаар төрийн албанд З жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах хүртэл арга хэмжээ авах;

2.1.4.дээрх зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх.

2.2. Зэвсэгт хүчний Жанжин штабын хүлээх үүрэг:

2.2.1.алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахын өмнө тухайн ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэхэд шаардагдах сургалт, бэлтгэлд хамруулж, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг хангуулах;

2.2.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцох хугацаанд алба хаагчийн албан тушаалыг хэвээр хадгалж, цалин хөлсийг итгэмжлэгдсэн этгээдэд олгох;

2.2.3.энэхүү гэрээнд заасан албан үүргээ онцгой сайн биелүүлсэн цэргийн алба хаагчийг төрийн шагналд тодорхойлох, шагнаж урамшуулах;

2.2.4.үүргээ гүйцэтгээд ирсний дараа томилолтын зардлыг олгох, нөхөн сэргээх, сувилалд хамруулах;

2.2.5.алба хаагчийн эрүүл мэндийн байдалд байнгын анхаарал тавьж, эмнэлгийн үйлчилгээгээр үнэ төлбөргүйгээр хангах, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт зааснаар ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалтай холбоотой БХЯ-ны шийдвэрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;

2.2.6.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үедээ цэргийн алба хаагч амь насаа алдах, хөдөлмөрийн чадвараа үзүүлж тохиолдолд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зааснаар тэтгэвэр, тэтгэмжийг, НҮБ-ын холбогдох журмын дагуу нөхөн олговрыг гаргуулж тус тус олгуулах;

2.2.7.шаардлагатай үед алба хаагчийг ар гэртэйгээ холбогдоход нь дэмжлэг үзүүлэх, тэднийг мэдээллээр хангах.

2.3. Алба хаагчийн эрх:

2.3.1.ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл болон үүрэг гүйцэтгэх хугацаанд өмнө авч байсан албан тушаалын цалин урамшууллыг бүрэн авах, хувийн дансандаа хадгалуулах, итгэмжлэлийн үндсэн дээр бусад этгээдэд олгуулах;

2.3.2.ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл болон үүрэг гүйцэтгэх хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хамгаалалтын хувцас хэрэглэл, байлдааны нэг бүрийн зэвсэг, хэрэгслээр хангагдах;

2.3.3.үүргээ гүйцэтгээд ирсний дараа өөрийн хүсэлтээр ээлжийн амралтаас гадна холбогдох журамд заасны дагуу нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх, сувилуулах, амрах;

2.3.4.цэргийн нийтлэг дүрмүүд болон офицерын болон ахлагч, цэргийн гэрээт алба хаах журмуудад заасан бусад эрх эдлэх.

2.4. Алба хаагчийн хүлээх үүрэг:

2.4.1.эх орныхоо болон цэргийн алба хаагчийн нэр хүндийг өндөрт өргөх, энхийг сахиулагч нарт тавигдах нийтлэг шаардлага, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх;

2.4.2.Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмийг мөрдөж, цэргийн багийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, хамтран зүтгэгч, нөхөртөө туслагч, дотны зөвлөгч нь байх;

2.4.3.ажиллагаа явагдаж буй тухайн улсын хууль тогтоомж, ёс заншилд хүндэтгэлтэй хандах;

2.4.4.үүрэг гүйцэтгэх хугацаанд өөрийн эрүүл мэндэд анхаарч, бие бялдрын болон сэтгэл санааны хувьд бэлтгэлтэй байх, НҮБ-ын болон холбогдох эмнэлгийн байгууллагын албан ёсны шийдвэрээр эрүүл мэндийн шалтгаанаар цаашид үүрэг гүйцэтгэх боломжгүй гэсэн дүгнэлт гараагүй тохиолдолд албаа үргэлжлүүлэн гүйцэтгэх;

2.4.5.цэргийн багийн болон хувийн аюулгүй байдлыг хангах;

2.4.6.ар гэртэйгээ холбоо барих, интернэт ашиглах зэрэгт мэдээллийн аюулгүй байдал, төрийн болон албаны нууцын горимыг чанд сахих, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр цэргийн багийн гүйцэтгэж байгаа үүрэг, үйл ажиллагаа болон алба хаагчдын хувийн болон албаны мэдээллийг хуулбарлах, бусдад дамжуулах, цэргийн багийн болон алба хаагчийн аюулгүй байдалтай холбогдох бүх төрлийн мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараахгүй байх;

2.4.7.томилогдсон албан тушаалын үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэж, итгэмжлэн хариуцуулсан зэвсэг, техник, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, хамгаалах.

Гурав. Бусад зүйл

3.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

3.2. Гэрээний үндсэн нөхцөлд заасан үүрэг хангагдсанаар гэрээ дуусгавар болно.

3.3. Цэргийн баг, алба хаагчийн үүрэг гүйцэтгэх хугацаа өөрчлөгдөж болохыг талууд урьдчилан зөвшөөрнө.

3.4. Гэрээтэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗХЖШ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

20..... оны дугаар сарын “ ”-ны өдөр

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ

..... АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
АЛБА ХААГЧ ЦОЛТОЙ-ны
..... / /

20..... оны ... дугаар сарын “ ”-ны өдөр

---оо---